

## ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ЗАГВАРЫН ТУРШИЛТ

### Хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулах материалын бүрдүүлэлт

Манай улсад хэмжих хэрэгслийн үндэсний үйлдвэрлэл хөгжөөгүй байгаа хэдий ч орчин үеийн технологи, шинжлэх ухаан техникийн дэвшил, үйлдвэрлэлийн автомат удирдлага, хяналтын систем, тоног төхөөрөмж өргөнөөр нэвтэрч, тэдгээрийг дагалдан өндөр нарийвчлалтай, электрон хэмжих багаж, хэмжлийн системийг өргөнөөр ашиглаж байна.

Монгол Улсын зах зээлийн эдийн засаг, нийгмийн харилцааны хэмжил зүйн үйл ажиллагаа нь Хэмжил зүйн тухай хуулиар зохицуулагдаж байгаа бөгөөд төрөөс хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хэмжих хэрэгслийн загварын туршилт юм.

Хэмжих хэрэгслийн загварын туршилтын ажлын эрх зүйн үндэс нь Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол Улсын Хэмжил зүйн төв байгууллага –Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 137 дугаар тушаалаар баталсан “**Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журам**” болно.

Хуульд зааснаар хэмжил зүйн төрийн хяналт шалгалтын хамрах үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх буюу импортоор нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллага нь хэмжих хэрэгслийн загварыг зохих норматив-техникийн болон ашиглалтын баримт бичгийн хамт Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад ирүүлэн туршилт хийлгэж баталгаажуулна.

А. Хэмжих хэрэгслийг анх удаа буюу шинээр загварын туршилтад хамруулахдаа дараах материалыг **Монгол хэл** дээр бүрдүүлнэ. Үүнд:

1. Стандарт, хэмжил зүйн газарт хандсан албан бичиг;
2. Өргөдлийн маягт бөглөж, албажуулна;
3. Хэмжих хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт, хэмжил зүйн ба техникийн үзүүлэлт, ажиллах зарчим, угсралт, холболтын бүдүүвч зураг, технологийн заавар зэргийг багтаасан техникийн баримт бичиг;
4. Хэмжих хэрэгсэлд хийх техник үйлчилгээ, суурилуулалт, угсралт, засвар тохируулгын талаарх мэдээлэл, гарын авлага, заавар;
5. Хэмжих хэрэгслийн ашиглалт, хадгалалтын талаарх хэрэглэгчид зориулсан гарын авлага бүхий баримт бичиг;
6. Хэмжих хэрэгслийн загвар (3 хүртэл);
7. Хууль эрхийн хэмжил зүйн олон улс байгууллагын болон үйлдвэрлэгч орны хэмжил зүйн үндэсний байгууллагын эсвэл эрх бүхий байгууллагын загварын баталгааны хүчин төгөлдөр гэрчилгээ, түүний баталгаат хуулбар, загварын туршилтын үр дүн, протокол тайлан;
8. Хэмжих хэрэгслийн программ хангамж, тоолуурын мэдээлэл дамжуулах протокол тайлан, программ хангамжийн эх үүсвэр бүхий код (source code) зэргийг цаас болон электрон хэлбэрээр ирүүлэх;
9. Хэмжих хэрэгслийн өнгөт зураг;
10. Үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагын танилцуулга;
11. **Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх чадавхаа үнэлүүлсэн, бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллага байх.**

Эдгээр материалыг электрон хэлбэрээр бүрдүүлэн ирүүлж болно

Б. Хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээний хугацааг сунгуулахдаа дараах материалыг **Монгол хэл** дээр бүрдүүлнэ. Үүнд:

1. Хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээг сунгуулах тухай албан бичиг;
2. Өргөдлийн маягт бөглөж, албажуулна;
3. Хэмжих хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт, хэмжил зүйн ба техникийн үзүүлэлт, ажиллах зарчим, угсралт, холболтын бүдүүвч зураг, технологийн заавар зэргийг багтаасан техникийн баримт бичиг;
4. Хэмжих хэрэгслийн загварын баталгааны гэрчилгээний хуулбар;
5. Хэмжил зүйн болон хяналтын байгууллага /МХЕГ/, хэрэглэгчээс тухайн хэмжих хэрэгслийн ашиглалтын талаарх тодорхойлолт, албан бичиг;

Эдгээр материалыг электрон хэлбэрээр бүрдүүлэн ирүүлж болно

Та загварын туршилтад тэнцэж, Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн хэмжих хэрэгслийн хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн бүртгэл болон дээр дурдсан журмыг СХЗГ-ын [www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn) сайтаас авч болох бөгөөд загварын туршилтын асуудлаар **18002525** утсанд хандаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө авна уу.

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар-13343, Энхтайвны өргөн чөлөө 46А, Баянзүрх дүүрэг,  
Жуковын музейн баруун талд Стандарт, хэмжил зүйн газар.

*Холбоо барих утас: өрөө: 264851*

*Цахим хуудас: <http://www.masm.gov.mn>,*

*E-мэйл: baigal\_b@masm.gov.mn*